

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03 дугаар сарын 17-ны өдөр

№ 26/16

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд
нэр дэвшигчдийг шалгаруулж, Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлаар хэлэлцүүлэх тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.5 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.3 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.14 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 24/07 тоот тогтоол, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх хорооны 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 26/02 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ-ийн 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн болон Хараат бус гишүүнд дараах нэр дэвшигчдийг дэвшүүлж, Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр тогтоосугай.
 - 1.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн гишүүн:
 - 1.1.1. Монгол Улсын иргэн Очирсүрэн овогтой Болдбаатар
 - 1.1.2. Монгол Улсын иргэн Баатархүү овогтой Хос-Эрдэнэ
 - 1.1.3. Монгол Улсын иргэн Цэрэндорж овогтой Ууганбаяр
 - 1.1.4. Монгол Улсын иргэн Пүрэвсүрэн овогтой Отгонбаяр
 - 1.1.5. Монгол Улсын иргэн Сэнгээ овогтой Энх-Амгалан
 - 1.1.6. Япон Улсын иргэн Кацухико Мадоно
 - 1.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн:
 - 1.2.1. Монгол Улсын иргэн Сандагжав овогтой Нэргүй
 - 1.2.2. Монгол Улсын иргэн Хөхийсүрэн овогтой Батсүрэн
 - 1.2.3. Монгол Улсын иргэн Цэвэгмид овогтой Түмэнцогт
2. Энэхүү тогтоолын 1-т заасантай холбогдуулан Компанийн ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 26/07 тоот тогтоолын Хавсралт №5а-д нэмэлт, өөрчлөлт оруулж энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг шинэчлэх, бусад шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Х.Хулан)-д даалгасугай.

